



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 01287

Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах  
"Бяцхан тэмүүлэл" төвийн  
барилга байгууламж, нийтийн эзэмшлийн  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 72 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/744 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 02-07-093/71 тоот актаар ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд байрлах Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Бяцхан тэмүүлэл" төвийн балансад бүртгэлтэй нийт 293,456,466.88 /хоёр зуун ерэн гурван сая дөрвөн зуун тавин зургаан мянга дөрвөн зуун жаран зургаан төгрөг наян найман мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Бяцхан тэмүүлэл төв /О.Туул/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг хоёрдогч түүхийн эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 7,556,400 /долоон сая таван зуун тавин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөгөөр борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т даалгасугай.

3. Өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Бяцхан тэмүүлэл төв /О.Туул/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050000727